Байгууллагын зорилго нь аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагуудад хяналт үнэлгээ хийх, мэргэжил арга зүй, удирдлагаар хангах оршино.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлагналдаа мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2019 онд өөрсдөө боловсруулсан боловч Төсвийн тухай хууль болон УСНББОУС-д нийцүүлэн Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан тодруулгын маягт, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал”-ыг бүрэн тусгаагүй, шинэчлээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аймгийн Эрүүл мэндийн газар 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлээгүй байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 842,672.9 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 12,640.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлаар тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Аймгийн Эрүүл мэндийн газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 236,098.9 мянган төгрөгөөр буюу 48.5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан эм боох материал, машин тоног төхөөрөмж, хуримтлагдсан үр дүнгийн данснууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

| | | /мянган төгрөг/ | |
|--|---|-------------------|-------------------|
| | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
| | Б | 1 | 2 |
| | Мөнгөн хөрөнгө | 0.00 | 0.00 |
| | Урьдчилж гарсан тооцоо | 549.31 | 5,000.00 |
| | Бараа материал | 179,128.24 | 428,319.32 |
| | Үндсэн хөрөнгө | 306,795.34 | 289,252.53 |
| | Нийт хөрөнгө | 486,472.89 | 722,571.85 |
| | Өр төлбөр | 2,906.80 | 842.50 |
| | Хуримтлагдсан үр дүн | 483,566.09 | 721,729.34 |
| | Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 486,472.89 | 722,571.85 |

Дансны үлдэгдэл гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Эм боох материал ковид-19 цар тахал гарсантай холбоотойгоор 247,760.9 мянган төгрөгөөр өссөн;
- Машин тоног төхөөрөмж 46,645.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн;
- Тайлант үеийн үр дүн 238,163.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн;
- Үндсэн хөрөнгө данс тайлант оны элэгдлийн зардлаас голлон шалтгаалж 17,542.8 мянган төгрөгөөр буурсан;

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Аймгийн Эрүүл мэндийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он | Өөрчлөлт |
|------------|---|---------------------|---------------------|------------------|
| 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Үйл ажиллагааны орлого | 2,135,040.09 | 8,184,408.13 | 6,049,368 |
| 11 | Татварын орлого | - | - | - |
| 12 | Татварын бус орлого | 565,574.45 | 5,093,981.31 | 4,528,407 |
| 120004 | Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас | 479,814.08 | 5,045,014.12 | 4,565,200 |
| 122 | Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих | 85,760.37 | 48,967.20 | (36,793) |
| 13 | Тусламж, санхүүжилтийн орлого | 1,569,465.64 | 3,090,426.82 | 1,520,961 |
| 1310 | Улсын төсвөөс санхүүжих | 1,505,091.90 | 1,836,559.10 | 331,467 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | - | - | - |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 64,373.7 | 1,253,867.7 | 1,189,494.0 |
| 1330 | Төсвийн захирагчаас | - | - | - |
| 1340 | НДС-аас санхүүжих | - | - | - |
| 14 | Бусад эх үүсвэр | - | - | - |
| 2 | Үйл ажиллагааны зардлын дүн | 1,959,295.02 | 7,939,252.88 | 5,979,958 |
| 21 | Урсгал зардал | 1,959,295.02 | 7,939,252.88 | 5,979,958 |
| 210 | Бараа, ажил үйлчилгээний зардал | 1,254,713.30 | 5,770,512.20 | 4,515,799 |
| 211 | Хүү | - | - | - |
| 212 | Татаас | - | - | - |
| 213 | Урсгал шилжүүлэг | 704,581.72 | 2,168,740.68 | 1,464,159 |
| 22 | Хөрөнгийн зардал | - | - | - |
| 3 | Үйл ажиллагааны үр дүн /3=1-2/ | 175,745.07 | 245,155.25 | 69,410 |
| 145 | Үйл ажиллагааны бус орлого | - | - | - |
| 225 | Үйл ажиллагааны бус зардал | 46,575.20 | 6,992.00 | (39,583) |
| 4 | Үйл ажиллагааны бус үр дүн /4=145-225/ | (46,575.20) | (6,992.00) | 39,583 |
| 5 | Нийт үр дүн /5=3+4/ | 129,169.87 | 238,163.25 | 108,993 |

Эрүүл мэндийн газрын санхүүгийн үр дүнгийн тайлангийн нэмэлт санхүүжилтийн орлого өмнөх оноос 1,189,494.0 мянган төгрөг буюу 94.9 хувиар өссөн, тайлант онд төлөвлөсөн санхүүжилтийг зарцуулж ажилласан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Эрүүл мэндийн газрын 2021 оны санхүүжилтийн эх үүсвэрийг 1,873,138.8 мянган төгрөг, үүнээс урсгал зардалд 1,873,138.8 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж төсвийн төслийг дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Сангийн яамнаас урсгал зардлыг 16,754.4 мянган төгрөгөөр бууруулан 1,856,384.4 мянган төгрөгөөр баталж тодотголоор 15,377.5 мянган төгрөгөөр бууруулж 1,841,006.9 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант онд ДЭМБ-аас 2021 онд “Ковид-19 цар тахлын эсрэг хариу арга хэмжээний чадавхыг бэхжүүлэх” хөтөлбөрийн хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Тус төлөвлөгөөг хэрэгжүүлэхээр ДЭМБ-т 2021 оны 9 дүгээр сарын 24-ний өдрийн 1/252 албан бичгээр хүргүүлж, Төсөв санхүү эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүжилтийн эрх нээлгэх хүсэлтийг Эрүүл мэндийн газрын даргын албан бичгээр хүсэлт тавьж шийдвэрлүүлснээс шалтгаалж 134,255.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 3,116,077.7 мянган төгрөгийг улсын төсвөөс, ДЭМБ-ын санхүүжилтээр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр үндсэн дансаар улсын төсвөөс 1,836,559.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлого 7,215.5 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны 149.3 мянган төгрөг, нэмэлт дансаар Төрийн болон болог орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандав, тусламж 170,007.8 мянган төгрөг, Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 55,285.2 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 1,015,508.7 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд 13,066.0 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч, 2,877,021.7 мянган төгрөгийг зарцуулж 220,769.9 мянган төгрөгийг төвлөрүүлж, 92.8 хувийн гүйцэтгэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,877,021.7 мянган төгрөг буюу 92.8 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 26,445.0 мянган төгрөг, аж олгогчийн НДШ 4,071.5 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 567.1 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардал 106.8 мянган төгрөг, нормативт зардал 39.9 мянган төгрөг, томилолтын зардал 32.7 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж зардлыг 950.2 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 2,213.9 мянган төгрөг, бусад урсгал шилжүүлгийг 147,630.7 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулснаас шалтгаалсан байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулалт нь үйл ажиллагааны урсгал зардал 211,974.9 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт-3 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

| Д/д | Хөтөлбөр, арга хэмжээний | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|-------------|--------------------------|--|---------------------|---------------------|-------------------|--------------|
| | Код | Нэр | | | | |
| 1 | 70407 | Стандартчилал, хэмжил зүй | - | - | - | |
| 1.1 | 80101 | Үндсэн үйл ажиллагааны зардал | - | - | - | |
| 2 | 71602 | Эмнэлгийн тусламж үйлчилгээ | 500.00 | - | 500.00 | 0.0% |
| 2.1 | 80101 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 500.00 | - | 500.00 | 0.0% |
| 2.2 | 80302 | Нэг иргэнд ногдох нормативаар | - | - | - | |
| 3 | 71603 | Эрүүл мэндийн бодлого, удирдлага | 3,115,077.69 | 2,879,663.51 | 235,414.18 | 92.4% |
| 3.1 | 80101 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 967,047.59 | 907,364.15 | 59,683.45 | 93.8% |
| 3.2 | 80103 | Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ | - | - | - | |
| 3.3 | 80802 | Ажил олгогчоос олгох тэтгэмж, | 2,128,701.50 | 1,952,970.77 | 175,730.74 | 91.7% |
| 3.4 | 83112 | Хөтөлбөр төслийн дотоод урсгал | 19,328.60 | 19,328.60 | - | 100.0% |
| <i>Нийт</i> | | | <u>3,115,577.69</u> | <u>2,879,663.51</u> | <u>235,914.18</u> | <u>92.4%</u> |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

- Тайлант онд ЭМЯ-аас орон нутагт нийт 1,447,896.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 4,874,859.8 мянган төгрөгийн бараа материал ирснээс аймгийн Эрүүл мэндийн газар 48.967.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 4,874,859.8 мянган төгрөгийн бараа материалыг орлогод авч 4,722,228.2 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлж, 1,447,896.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг ЭМГ-ын даргын тушаалаар нэгдсэн эмнэлэг, сумын Эрүүл мэндийн төвүүдэд хуваарилан

хүргүүлсэн байна. ЭМГ нь тус үндсэн хөрөнгийг холбогдох дансаар дамжуулалгүй шууд сумын ЭМТ-үүдэд олгож байгаа нь НББ-ийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузал сууриар хөтөлнө” гэж заасны хэрэгжүүлж ажиллаагүй нь НБББББ-т дамжуулах үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгийг хэрхэн бүртгэх, тайлагнах талаар тусгагдаагүйгээс шалтгаалсан байна. Энэ нь хөрөнгө үргүйдэх, эзэн холбогдогчгүй болох, хууль журам зөрчигдөх үндэслэл болж байна.

- ЭМЯ-ны албан бичиг, ЭМС-ын тушаалаар санхүүгийн асуудал хариуцсан албан хаагчдыг урамшуулж шагнах шийдвэр гаргаснаар тухайн байгууллагын ажилтан албан хаагч үндсэн ажил үүргээ гүйцэтгэснийг үнэлж буй нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралттай нийцэхгүй байна. Иймд Төсвийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.4.2-д заасны дагуу эрх бүхий албан тушаалтан Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтад заасны дагуу үр дүнг үнэлэх асуудал тусгахаар шийдвэр гаргахад анхаарах шаардлагатай байна.

3.8 Аудитын гол асуудал

Эрүүл мэндийн газрын санхүүгийн тайлангийн аудитад нөлөөлөх гол асуудал байхгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан local.audit.mn цахим бүртгэлийн хүрээнд мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Эрүүл мэндийн газрын 2021 онд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын нийт 5,699.5 сая төгрөгийн 118 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас орлогын 3,248.7 сая төгрөгийн 42, зарлагын 2,450.8 сая төгрөгийн 76 мэдээллийг ил тод байршуулаагүй зөрчилтэй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Коронавируст халдвар тархсантай холбоотойгоор тайлант онд Эрүүл мэндийн сайд, сангийн сайдын А/337,99 67/А/268 хамтарсан тушаалаар хоёр удаагийн журам, Эрүүл мэндийн сайдын А/605 дугаар тушаалаар “Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлөөс 03, 04 дүгээр тоот тогтоолоор “Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай”, Эрүүл мэндийн сайдын А/248, А/415 тоот тушаалаар илүү цагаар

ажилласны нэмэгдэл, А/496, А/585 тоот тушаалаар мөнгөн тэтгэмж олгох, А/575, А/581 тоот тушаалаар хөрөнгө гаргах, А/788 тоот тушаалаар эрх шилжүүлэх, А/803 тоот тушаалаар нэг удаагийн мөнгөн урамшуулал олгох тус тус шийдвэрийг гаргасан байна.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудит хийгдээгүй болно.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн шилэн дансны цахим хуудсанд 43 мэдээг хугацаа хоцроож, 29 мэдээг байршуулаагүй зөрчилд 1 албан шаардлагын биелэлт 98.3 хувь, 30,450.0 мянган төгрөгийн 2 зөвлөмжийн хэрэгжилт 93.7 хувьтай байна.

Хүснэгт-4 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|-----------------|---------------------|----------------|----------|----------------|----------|----------|----------|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 2 | 6088.9 | 2 | 6088.9 | 0 | 0 | 0 |
| Зөвлөмж | 4 | 7,625.7 | 4 | 7083.0 | 0 | 542.7 | 7.1 |
| Нийт дүн | 6 | 13714.6 | 6 | 13171.9 | 0 | 0 | 0 |

Үндсэн хөрөнгийн тавилга хэрэгслийн дансанд 5 төрлийн 1266.0 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй тоног төхөөрөмж бүртгэснийг залруулж, 842.5 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй тайлагнасан нь зөвлөмжийг давтан гаргасан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

ДЭМБ-аас 2021 онд “Ковид-19 цар тахлын эсрэг хариу арга хэмжээний чадавхыг бэхжүүлэх” хөтөлбөрийн үр дүнг дараагийн аудитаар авч үзнэ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 30,261.9 мянган төгрөгийн 11 алдаа зөрчил илэрснээс, 17,848.9 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, 1,544.3 мянган төгрөгийн 2 зөрчилд акт, 10,026.3 мянган төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага хүргүүлж, 842.5 мянган төгрөгийн алдаа зөрчилд 3 зөвлөмж өглөө.

Залруулагдаагүй 9 алдаа, зөрчлийн дүн 12,413.0 мянган төгрөг нь тогтоосон ерөнхий материаллаг байдал 12,640.0 мянган төгрөгөөс хэтрээгүй тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Үр дүнгийн тайланд томилолтын урьдчилгаа болон цалингийн урьдчилгааг холбогдох дансаар дамжуулаагүй;
- Үндсэн хөрөнгийн элэгдэл 1,410.9 мянган төгрөгөөр дутуу тооцоолсон

4.2 Төлбөрийн акт

1. Харьяалал бүхий сумын төвдөө ажиллаж буй найман эмчид нийт 882,600.00 төгрөгийн томилолт олгосон байна.

Энэ нь Сангийн сайдын 2018 оны 301 дугаар тушаалаар батлагдсан “Зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай” -ыг 2-т “Албан томилолтоор ажиллах төрийн албан хаагчийн байр, зам хоног, уналгын зардлын төсвийг тухай бүр баталсны үндсэн дээр олгох, шаардлагагүй тохиолдолд төрийн албан хаагчид байрны зардал төсөвлөн олгохгүй байхыг төсөвт байгууллагын болон төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын дарга нарт зөвлөсүгэй”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон томилолтын зардал 882,600.00 төгрөгийг аймгийн төсвийн орлогоор төвлөрүүлэх, Төлбөрийн акт тогтоох.

2. Тайлант хугацаанд ажилчин албан хаагчийг шагнаж урамшуулахдаа 649,000.00 төгрөгийг илүү тооцон олгосон байна.

Энэ нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын нэг дүгээр хавсралтын 3.3-т “Мөнгөн шагналыг төрийн онцгой чухал буюу онц түвэгтэй албан даалгавар биелүүлсэн, төрийн байгууллагын үйл ажиллагаа, төрийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж хэрэглээнд нэвтрүүлсэн төрийн албан хаагчид олгож болно. Байгууллагын удирдлагын шийдвэрээр тухайн ажилтныг шагнах мөнгөн шагналын хэмжээ нь сарын үндсэн цалинг 1.5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хүртэл хэмжээтэй байна”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон шагналын 649,000.00 төгрөгийг аймгийн төсвийн орлогоор төвлөрүүлэх, Төлбөрийн акт тогтоох

4.3 Албан шаардлага

1. Тайлант онд цалин тооцон олгохдоо нийт 121,720,720.00 төгрөгийн НДШ, ХХОАТ-ын өглөгийг шууд журналын бичилт хийн бүртгэж тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-д “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах” үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох стандарт, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт заасны дагуу журналыг хөтөлж зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарах, Албан шаардлага өгөх.

2. Тооллогыг Эрүүл мэндийн газрын А/102 тоот тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэй комисс томилогдон 12 дугаар сарын 14-нд тооллогыг хийж дууссан бөгөөд тооллого хийгдсэнээс хойш 16,451,000.00 төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдэж 792,000.00 төгрөгийн зарцуулалт, бараа материалын хувьд 276,401,400.00 төгрөгийн орлого, 235,705,800.00 төгрөгийн зарцуулалт хөдөлгөөн хийгдсэн ч тооллогын дүн 12 дугаар сарын 31-ний үлдэгдлээр тоологдсон нь тооллогыг үнэн зөв, бодиттой хийгээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 4 дэх "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх", гэсэн заалттай нийцэхгүй, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу баримтжуулах, үр дүнг тооцох, архивын нэгж болгох, зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах, Албан шаардлага өгөх.

3. Эрүүл мэндийн яамнаас ирсэн үндсэн хөрөнгийг орлогод авахгүй тушаалаар сумдын Эрүүл мэндийн төвүүдэд шилжүүлдэг, зарим нэг удаагийн шинжтэй бараа материалыг үндсэн хөрөнгөөр орлогод авхуулдаг, Эрүүл мэндийн төвүүдэд шилжүүлсэн бараа материалын үнийн дүн, тоо хэмжээнд өөрчлөлт оруулдаг, Эрүүл мэндийн төвүүдтэй тооцоо нийлсэн акт үйлддэггүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-д "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралтын НХМаягт ТМЗ-ыг хэрэгжүүлэх, үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох стандарт, хууль журмын дагуу шийдвэрлэж, зөрчлийг таслан зогсоох, Албан шаардлага өгөх.

4. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 42 удаагийн 3.248,716.800.00 төгрөгийн орлого, 76 удаагийн 2,450,810,400.00 төгрөгийн зарлагын гүйлгээг шилэн дансанд мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ ... 6.4.5-д цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр..." заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д заасны дагуу мэдээллийг үнэн зөв мэдээлж, зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах, Албан шаардлага өгөх.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Албан хаагчдад илүү цагаар ажилласны нэмэгдэл хөлсийг тооцон олгохдоо илүү цагийн тооцооллыг бүрэн хийлгүй олгосон байна.

Энэ нь Засгийн газрын 2019 оны 382 дугаар захирамжийн 2 дугаар хавсралтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Засгийн газрын 2019 оны 382 дугаар захирамжийн 2 дугаар хавсралтыг бүрэн хэрэгжүүлж ажиллах

2. Өглөгтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант хугацаанд тооцооллыг тухай бүр хийгээгүйгээс 842.5 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэснийг хэрэгжүүлж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх

3. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас худалдан авалт хийхдээ НӨАТ-ын баримтгүй нийт 63,615.8 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Худалдан авалтын НӨАТ-ын баримтыг авч хэвшинэ.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| № | Аудитын код | Алдаа, зөрчлийн товч утга | Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга | Нийт алдаа, зөрчлийн дүн | | Үүнээс | | | | | | | | | |
|---|-------------------------|---|---|--------------------------|-------|-----------|-------|-----|-------|-----------------|-----|-------------------|-----|---------|-------|
| | | | | | | Залруулга | | Акт | | Албан шаардлага | | Хариуцлага тооцох | | Зөвлөмж | |
| | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 | 15 |
| 1 | БУА-2022/147/НА-СТА-ТШЗ | Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 42 удаагийн 3.248,716.800.00 төгрөгийн орлого, 76 удаагийн 2,450,810,400.00 төгрөгийн зарлагын гүйлгээг шилэн дансанд мэдээлээгүй байна. | Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д заасны дагуу мэдээллийг үнэн зөв мэдээлж, зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах | 1 | 0 | | | | | 1 | 0 | | | | |
| 2 | БУА-2022/147/НА-СТА-ТШЗ | Тайлант хугацаанд тооцооллыг тухай бүр хийгээгүйгээс 842.5 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй байна | Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэснийг хэрэгжүүлж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх | 1 | 842.5 | | | | | | | | | 1 | 842.5 |
| 3 | БУА-2022/147/НА-СТА-ТШЗ | Тайлант онд цалин тооцон олгохдоо нийт 121,720,720.00 төгрөгийн НДШ, ХХОАТ-ын өглөгийг шууд журналын бичилт хийж тайлагнасан байна. | Холбогдох стандарт, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт заасны дагуу журналыг хөтөлж зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч | 2 | 16438 | 1 | 16438 | | | 1 | 0 | | | | |
| 4 | БУА-2022/147/НА-СТА-ТШЗ | Харьяалал бүхий сумын төвдөө ажиллаж буй найман эмчид нийт 882.600.00 төгрөгийн томилолт олгосон байна. | Сангийн сайдын 2018 оны 301 дугаар тушаалаар батлагдсан "Зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай" -ыг 2-т "Албан томилолтоор ажиллах төрийн албан хаагчийн байр, зам хоног, уналгын зардлын төсвийг тухай бүр баталсны үндсэн дээр олгох, шаардлагагүй тохиолдолд төрийн албан хаагчид байрны зардал төсөвлөн олгохгүй байхыг төсөвт байгууллагын болон төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын дарга нарт зөвлөсүгэй", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн | 1 | 882.6 | | | 1 | 882.6 | | | | | | |

Аймгийн Эрүүл мэндийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

| | | | | | | | | | | | | | | | |
|-----|-------------------------|--|--|----|--------|---|--------|---|--------|---|-------|---|---|---|-------|
| | | | 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах | | | | | | | | | | | | |
| 5 | БУА-2022/147/НА-СТА-ТШЗ | Албан хаагчдад илүү цагаар ажилласны нэмэгдэл хөлсийг тооцон олгохдоо илүү цагийн тооцооллыг бүрэн хийлгүй олгосон байна. | Засгийн газрын 2019 оны 382 дугаар захирамжийн 2 дугаар хавсралтыг бүрэн хэрэгжүүлж ажиллах | 1 | 0 | | | | | | | | | 1 | 0 |
| 6 | БУА-2022/147/НА-СТА-ТШЗ | ЭМЯ-ны 2021.09.13-ны 1а/4901 албан бичиг, ЭМС-ын 2021.09.10-ны А/567 дугаар тушаал, ЭМГ-ийн 2021.09.17-ны Б/40 тушаалаар төсвийн мэргэжилтэн, нягтлан бодогч нарыг 2 сарын үндсэн цалингаар шагнаж урамшуулсан байна. | Тасгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын нэг дүгээр хавсралтын 3.3-т, Төсвийн тухай хуулийн 40.4.2-т заасныг зөрчсөн байна. | 1 | 661.65 | | | 1 | 661.65 | | | | | | |
| 7 | БУА-2022/147/НА-СТА-ТШЗ | Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас худалдан авалт хийхдээ НӨАТ-ын баримтгүй нийт 63,615.8 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн | Худалдан авалтын НӨАТ-ын баримтыг авч хэвшинэ. | 1 | 0 | | | | | | | | | 1 | 0 |
| 8 | БУА-2022/147/НА-СТА-ТШЗ | ЭМЯ-аас ирсэн үндсэн хөрөнгийг орлогод авахгүй тушаалаар сумдын ЭМТ-үүдэд шилжүүлдэг, зарим нэг удаагийн шинжтэй бараа материалыг үндсэн хөрөнгөөр орлогод авхуулдаг, ЭМТ-үүдэд шилжүүлсэн бараа материалын үнийн дүн, тоо хэмжээнд өөрчлөлт оруулдаг, ЭМТ-тэй тооцоо нийлсэн акт үйлддэггүй байна. | Холбогдох стандарт, хууль журмын дагуу шийдвэрлэж, зөрчлийг таслан зогсоох | 1 | 10026 | | | 1 | 10026 | | | | | | |
| 9 | БУА-2022/147/НА-СТА-ТШЗ | Тооллогыг Эрүүл мэндийн газрын А/102 тоот тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэй комисс томилогдон 12 дугаар сарын 14-нд тооллогыг хийж дууссан бөгөөд тооллого хийгдсэнээс хойш 16,451,000.00 төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдэж 792,000.00 төгрөгийн зарцуулалт, бараа материалын хувьд 276,401,400.00 төгрөгийн орлого, 235,705,800.00 төгрөгийн зарцуулалт хөдөлгөөн хийгдсэн ч тооллогын дүн 12 дугаар сарын 31-ний үлдэгдлээр тоологдсон нь тооллогыг үнэн зөв, бодиттой хийгээгүй байна. | Хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу баримтжуулах, үр дүнг тооцох, архивын нэгж болгох, зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах | 1 | 0 | | | 1 | 0 | | | | | | |
| 10 | БУА-2022/147/НА-СТА-ТШЗ | Үндсэн хөрөнгийн элэгдлийг буруу тооцоолсон. | Холбогдох стандарт, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт заасны дагуу журналыг хөтөлж залруулах | 1 | 1410.9 | 1 | 1410.9 | | | | | | | | |
| ДҮН | | | | 11 | 30262 | 2 | 17849 | 2 | 1544.3 | 4 | 10026 | 0 | 0 | 3 | 842.5 |